



Европын Холбоо
санхүүжүүлэв



ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗӨВЛӨХ БАГ

Байгууллага: Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага

Төсөл: Шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагаа ба ил тод байдал (2024-2026)

Материал хүлээн авах хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 18.00 цаг

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ) энх тайван, шударга ёс, тогтвортой хөгжлийг дэмжин, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн салбарт шинэчлэл хийх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд улс орнуудын засгийн газар болон ард иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэн, ажилладаг байгууллага юм. ОУЭЗХБ-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим болон твиттер хуудас (www.idlo.int, Twitter @IDLO)-наас авна уу.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

ОУЭЗХБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар нь Европын Холбооны санхүүжилтээр “Шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагаа ба ил тод байдал 2024-2026” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь иргэний нийгмийн байгууллага (ИНБ) болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоотойгоор шүүх эрх мэдлийн салбарын хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд оршино. Шүүхийн байгууллагын ил тод байдал, олон талт хамтын ажиллагааг сайжруулснаар шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

АЖЛЫН ХҮРЭЭ, ДААЛГАВАР

Зөвлөх баг нь ажлын даалгаврын дагуу сэтгүүлчид болон ИНБ-ын сургалтын хэрэгцээг тодорхойлон, эрх зүй, шүүхийн тогтолцоо, цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч зэрэг хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үүрэг оролцоо, ИНБ-ын оролцоотой шүүх байгууллагын үйл ажиллагааг хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавих, болон шүүх байгууллагын үйлчилгээ дэх охид, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, үндэстний цөөнх, ЛГБТИ хүмүүсийн эрх, тусгай хэрэгцээ шаардлагын талаар суурь мэдлэг олгох 2 өдрийн 2 удаагийн сургалтыг тус бүр 25 сэтгүүлч, 25 ИНБ-ын төлөөллийг хамруулан зохион байгуулна. Ингэхдээ Төслийн зохицуулагч болон Хөтөлбөрийн менежерийн шууд удирдлага дор дараах ажлыг гүйцэтгэнэ:

- Эхлэлтийн тайлан боловсруулан, ажлын календарчилсан төлөвлөгөө, сургалтын хэрэгцээ тодорхойлох үнэлгээний арга зүй, бүтэц, санал болгож буй сургалтын хөтөлбөрийн бүтцийг тусгана.
- Сургалтын хэрэгцээ тодорхойлох асуумжийн дагуу дүн шинжилгээ хийн, үнэлгээний тайланд ОУЭЗХБ, Шүүхийн Ерөнхий зөвлөл, болон бусад холбогдох байгууллагын саналыг тусган, тайланг эцэслэнэ.

- Сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулан ОУЭЗХБ, бусад сургагч багш нар болон холбогдох талд танилцуулан, саналыг тусгана.
- Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу хоёр удаагийн сургалтыг зохион байгуулна.
- Гүйцэтгэлийн тайланд хийсэн ажлыг дэлгэрэнгүй тусгаж, гарсан хүндрэл бэрхшээл, санал зөвлөмжийг тусган Монгол хэл дээр бэлтгэж хүргүүлнэ.



Ажлын даалгаврын дэлгэрэнгүйг дараах холбоос болон QR кодыг уншуулан авч танилцана уу: <https://bit.ly/3Y2vXux>

ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх багийн ахлагч (1 хүн) дараах ур чадварыг эзэмшсэн байна:

- i. Эрх зүй, хүний эрх, төрийн удирдлага болон холбогдох чиглэлээр магистраас дээш зэрэгтэй;
- ii. Мэргэжлээрээ 5-аас дээш жилийн ажлын туршлагатай;
- iii. Сургалтын хэрэгцээ тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, хичээл заах чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- iv. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо, үйлчилгээний талаар маш сайн мэдлэгтэй, ажилласан туршлагатай;
- v. Баг удирдах зохион байгуулах чадвартай;
- vi. Харилцааны өндөр соёлтой байх;

Зөвлөх багийн гишүүн (1 хүн) дараах ур чадварыг эзэмшсэн байна:

- i. Нийгмийн шинжлэх ухаан, сэтгүүл зүй, мэдээлэл харилцаа болон холбогдох чиглэлээр магистраас дээш зэрэгтэй;
- ii. Мэргэжлээрээ 3-аас доошгүй жилийн ажлын туршлагатай;
- iii. ИНБ, хэвлэл мэдээллийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- iv. Сургалт зохион байгуулах, хичээл заах чиглэлээр ажилласан туршлагатай;
- v. Эрх зүй, шүүхийн тогтолцоо болон хүний эрх, жендэрийн тэгш байдлын талаар ойлголт, мэдлэгтэй;
- vi. Багаар ажиллах чадвартай
- vii. Харилцааны өндөр соёлтой байх;

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Зөвлөх багаар ажиллах сонирхлоо илэрхийлсэн хүсэлт
- Багийн гишүүдийн товч намтар, анкет
- Сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалт зохион байгуулсан туршлагын талаарх мэдээлэл бүхий жагсаалт.

Сонирхсон зөвлөх баг материалаа 2024 оны 11 дугаар сарын 08-ны дотор ubyambaa@idlo.int цахим хаягт ирүүлнэ үү.